



# МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 07 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар ХЭГ  
19-73

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.УЧРАЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000789

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.УЧРАЛДААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУЛГЫН ХАРИУ

“Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Зөвлөлийг Гадаад харилцааны сайд даргалдаг бөгөөд ээлжит хуралдааныг 2019 оны 7 дугаар сард багтаан зохион байгуулж, цаашид хүрэх үр дүн болон төлөвлөсөн ажлын талаарх мэдээллийг Танд хүргүүлэх болно.

Уг хөтөлбөрийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлттэй танилцана уу.

№	Хөтөлбөрийн үндсэн арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
<b>НЭГ. БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>				
1.	Хилийн чанадад 3 сараас дээш хугацаагаар болон байнга оршин сууж буй иргэдийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох	2016–2020	Хилийн чанадад оршин сууж буй монгол иргэдийн цахим бүртгэлийн мэдээллийг шинэчлэх	Хилийн чанадад ажиллаж, сурч, цагаачлан суугаа болон хууль бусаар амьдарч буй монгол иргэдийн цахим бүртгэлийг 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн ГХЯ-ны Консулын газрын <a href="http://cizen.gov.mn/">http://cizen.gov.mn/</a> цахим хаягаар бүртгэж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар дэлхийн 76 улсад 175 000 гаруй монгол иргэд, үүнээс 50 000 гаруй иргэн нь хөдөлмөр эрхэлж, 49 000 орчим иргэн сурч байгаа болно.
2.	Хоёрдмол үүсгэсэн монгол иргэдийн мэдээллийн санг бий болгох		Хоёрдмол харьяалал үүсгэсэн монгол иргэдийн мэдээллийн санг бий болгох	Хоёрдмол харьяалал үүсгэсэн монгол иргэдийн мэдээллийн санг бий болгох чиглэлээр ажиллаж байна.
3.			Монгол иргэдийн цахим бүртгэлийн талаар холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулах	Иргэдийн цахим бүртгэл эрхэлдэг газрууд болох УБЕГ, УХГ, Үндэсний дата төв, ГИХГ-тай уулзалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.
4.	Хилийн оршин иргэдийн боловсрол, чадварын зорилгот судалгааг хийх	2016–2020	Хилийн чанадад нарийн мэргэжлээр сурч буй болон академик ажил эрхэлж буй монгол иргэдийн судалгааг шинэчлэх	Хилийн чанадад нарийн мэргэжлээр сурч байгаа болон академик ажил эрхэлж буй монгол иргэдийн судалгааг хилийн чанадад суугаа ДТГ-уудаар дамжуулан энэ оны 3 дугаар сард хүлээн авч нэгтгэв. Энэ оны эхний улирлын байдлаар дэлхийн 25 улсад 307 монгол иргэн нарийн мэргэжлээр (анагаах ухаан, хууль эрх зүй, агрономич, мэдээллийн технологи, уллуурхайн инженер) сурч буй болон академик ажил эрхэлж буй бөгөөд үүнээс 109 иргэн нь оюутан, 198 иргэн академик ажил эрхэлж байгаа болно.

5.		Хилийн чанад дахь оюутнуудын мэдээллийн санг бүрдүүлэх	Хилийн чанадад суралцаж буй оюутнуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. 2012-2018 оны хугацаанд Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаадад нийт 8,088 суралцагч суралцсан бөгөөд эдгээр суралцагчдын 7000 гаруй буюу 89 хувь нь Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу, 900 гаруй буюу 11 хувь нь "Боловсролын зээлийн сан"-ийн зээлийн санхүүжилтээр суралцсан байна. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцаж буй суралцагчдыг суралцаж буй орноор нь харуулбал, ОХУ-д 35 хувь, БНХАУ-д 34 хувь, Унгар Улсад 8 хувь, Япон Улсад 5 хувь, Турк Улсад 4 хувь нь суралцаж байгаа болно.
6.	ДТГ-уудад үйлчилгээг хүргэх бүрдүүлэх цахимаар боломжийг	2016-2020	Хилийн чанад дахь 16-аас доош насны хүүхдүүдийн гадаад паспортын захиалгыг ДТГ-уудаар дамжуулан тусгай сүлжээгээр хүлээн авах чиглэлээр ажиллах
7.	Хилийн оршин иргэдийг бүртгэлд хамруулах, баримтгүй, баримтын иргэдийн шийдвэрлэх сууж буй шинэчилсэн бүрэн бичиг бичиг зөрчилтэй асуудлыг	2016-2020	Хилийн чанад дахь монгол иргэдийг цахим бүртгэлд хамруулах чиглэлээр сурталчлан тануулах арга хэмжээг зохион байгуулах
<b>ХОЁР. ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ ИРГЭДИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>			
8.	Гадаадад сургууль ажлын байраар хангах, гадаадад ажлын хангасан болон их, дээд төгсөгчдийг төгсөгчдийг байраар үндэсний гадаадын	2016-2020	Ажил олгогчийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байсан гадаадад төгсөгчдийг ажлын байраар хангасан хуулийн
Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 7.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэн, ажил идэвхтэй хайж байгаа боловч 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доош хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн тэнцэх хэмжээний урамшууллыг бий болгосон ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно" гэж заасан байдаг.			

<p>хөрөнгө оруулалттай хуулийн дэмжлэг тогтолцоо асуудлаар судалгаа хийх</p>	<p>орлуулалттай этгээдэд үзүүлэх бий болгох судалгаа</p>	<p>Этгээдэд дэмжлэг үзүүлэх арга үргэлжлүүлэн хэрэгжүүлэх</p>	<p>Энэхүү хөтөлбөрийн заалтыг тайлангийн хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.</p>
<p>9</p>	<p>Засгийн газрын тэтгэлтийг үр дүнтэй ашиглах үүднээс гадаадад тэтгэлгээр суралцаж төгссөн оюутнуудыг ажлын байраар хангах чиглэлээр ажиллах, эх орондоо ажилд зуучлахад зориулагдсан программ хангамжийг шинээр бий болгох, хөгжүүлэх асуудлыг судлах, тооцоолол гаргах</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний системийг шинэчлэх ажлыг төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд системийн талаарх судалгааг хийж гүйцэтгээд байна. Энэ ажлын хүрээнд гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдэд эх орондоо ажилд зуучлагдахад зориулсан программ хангамжийг шинээр бий болгох асуудлыг судалж байна.</p>	
<p>10</p>	<p>Гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх асуудлаар судалгаа хийх</p>	<p>2016-2020</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу хувиараа хөдөлмөр эрхлэх, бичил аж ахуй эрхлэх, өргөтгөх хүсэлтэй иргэдэд 10.0 сая хүртэл, шинээр ажлын байр бий болгох нөхөрлөл, хоршоо, аж ахуй нэгжид 20.0 хүртэл сая төгрөгийн жижиг зээлийг 2 жилийн хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн хүүтэйгээр олгож байна.</p>
<p>11</p>	<p>Гадаадад сурч, ажиллаж байсан залуусыг дэмжих, ажлын байраар хангах талаар дэд хөтөлбөр боловсруулах</p>	<p>Гадаадад сурч, ажиллаж байсан залуусыг дэмжих, ажлын байраар хангах талаар дэд хөтөлбөр боловсруулах</p>	<p>Гадаадад сурч, ажиллаж өндөр мэдлэг, боловсрол, технологи, үр чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо тогтвор суурьшилтай ажиллахад 5.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. 2019 оны эхний улиралд хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн сургалтыг 21 аймаг, 9 дүүргийн сум, хороодын 1200 ажилтан, албан хаагчдад зохион байгуулсан. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.</p>
<p>12</p>	<p>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөдөлмөрийн үзэсгэлэн, яармагийг зохион байгуулах</p>	<p>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөдөлмөрийн үзэсгэлэн, яармагийг зохион байгуулах</p>	<p>ХНХЯ 2019 оны 4 дүгээр сард Япон Улстай "Ур чадвартай ажилтан илгээх болон хүлээн авах тухай хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг байгуулсан. Уг санамж бичиг нь Монгол Улсын иргэд Япон Улсад хөдөлмөрийн гэрээгээр япон ажилтантай адил нөхцөлд, адил цалин хөлстэй ажиллах боломжийг бүрдүүлж байна. Үндэсний хөдөлмөрлөх эрхийг хангах, нийгмийн халамжид хамрагдах, Япон</p>

				<p>Улсад оршин суухтай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх зэрэг хууль ёсны эрхийг хангах асуудлыг тусгасан.</p> <p>Монгол Улсын иргэд олноороо ажилладаг улс орнуудтай манай иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа болон Япон Улсад ур чадварын дадлагажигчаар ажиллаж байгаа иргэдийн дунд өдөрлөг, уулзалт зохион байгуулах зэрэг хэд хэдэн ажлыг төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Өдөрлөг уулзалтын үеэр гадаадад ажиллаж байгаа монгол иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал болон салбарын бусад үйлчилгээ, арга хэмжээг сурталчилан таниулах, иргэдийн санал бодлыг сонсох, зөвлөгөө өгөх, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх зэрэг ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.</p>
13	<p>Гадаадын иргэншилтэй болсон Монгол Улсад зорчих, оршин суух, бизнес эрхлэх нөхцлийг хөнгөвчлөх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх</p>	2016-2020	<p>"Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "Гадаадын иргэншилтэй болсон Монгол иргэдийн Монгол Улсад зорчих, оршин суух, бизнес эрхлэх нөхцлийг хөнгөвчлөх" талаар тодорхой санал боловсруулах</p>	<p>"Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "Гадаадын иргэншилтэй болсон монгол иргэдийн Монгол Улсад зорчих, оршин суух, бизнес эрхлэх нөхцлийг хөнгөвчлөх" чиглэлээр санал боловсруулж байна.</p>
14	<p>Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийг Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Полш Улс зэрэг улсуудтай эцэслэн тохиролцож байгуулах</p>	2016-2020	<p>"Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг байгуулах чиглэлээр ажиллах</p>	<p>"Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг Засгийн газрын болон Байнгын хорооны хурлаар хэлэлцэн зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоод байна.</p>
15	<p>Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Бүгд Найрамдах Казахстан Улстай байгуулах</p>			<p>Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын Тэтгэврийн хангамжийн тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх Монгол-Казахстаны ажлын хэсгийн шинжээчдийн гурав дахь удаагийн хуралдаан 2019 оны 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Казахстан Улсын Нур-Султан хотноо болов. Хэлэлцээрт Монголын талаас ХНХЯ, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монгол Улсаас БНКаэу-д суугаа ЭСЯ, Казахстаны талаас Хөдөлмөр ба хүн амын нийгмийн хамгааллын яам, "Иргэдийн Төлөөх Төр" Улсын Корпораци"-ийн төлөөлөгчид тус тус оролцсон. Хэлэлцээний үеэр ажлын хэсгийн шинжээчид хэлэлцээрийн зүйл, заалтуудын талаар санал солилцсон болно.</p>

16			<p>Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Америкийн Нэгдсэн Улстай байгуулах чиглэлээр ажиллах</p>	<p>Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Америкийн Нэгдсэн Улстай байгуулах асуудлын хүрээнд Америкийн талтай хэлэлцээр хийх талаар санал, мэдээлэл солилцох шатанд явж байгаа болно.</p>
17			<p>"Монгол Улс, ОХУ-ын хооронд нийгмийн хамгааллын салбар дахь хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийг байгуулах чиглэлээр ажиллах</p>	<p>Монгол Улс, Оросын Холбооны Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулж, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох, шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг харилцан шилжүүлэх, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх талаар Оросын талтай ажиллаж байна.</p>
18			<p>Монгол Улс, Шведийн Хаант Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулах яриа хэлэлцээг үргэлжлүүлэх</p>	<p>Монгол Улс, Шведийн Хаант Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулах асуудлын хүрээнд Монголын тал Шведийн Вант Улстай нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр байгуулах саналыг албан ёсоор тавив. Одоогоор Шведийн талаас хариу хүүлээж байгаа болно.</p>
19	2016–2020		<p>Нийгмийн хамгааллын хэлэлцээрийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хилийн чанад дахь монголчуудын холбоодын цахим хуудас болон холбогдох төрийн байгууллагуудын цахим хуудаст тогтмол байршуулан мэдээлэх</p>	<p>ХНХЯ нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалд хэрхэн хамрагдах, сайн дураар даатгалд хамрагдах гэрээ байгуулах, шимтгэл төлөх болон нийгмийн хамгааллын хэлэлцээрийн талаарх мэдээ, мэдээлэл, сурталчилгааг вэб сайт, facebook, бусад цахим сүлжээнд байнга байршуулж танилцуулж, сурталчилж байна. ГХЯ 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 09/1061 тоот албан бичгээр нийгмийн хамгааллын хэлэлцээрийг сурталчлах тодорхой мэдээлэл бүхий гарын авлагыг цахим хэлбэрээр бэлтгэн ХНХЯ-нд хургуулав. Түүнчлэн нийгмийн даатгалын чиглэлээр гарсан хууль, тогтоомж, дүрэм журмыг хилийн чанад дахь иргэдэд сурталчлан таниулах зорилгоор Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой хууль тогтоомжийн эмхтгэлийг боловсруулж байна.</p>
20	2016–2020		<p>Патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах чиглэлээр үүлзалт, семинар зохион байгуулах</p>	<p>Гадаадын өндөр хөгжилтэй орны патент, өндөр технологи, инновацийн талаар судалгаа хийх чиглэлээр ажиллаж байна.</p>

21	Патент, өндөр технологи, инновацийг нутаглашуулах шинэ санал санаачлагад бодлогын зээлийн дэмжлэг үзүүлэх	2016-2020	Патент, өндөр технологи, инновацийг нутаглашуулах шинэ санаачилгаанд санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх ажиллах	Патент, өндөр технологи, инновацийг нутаглашуулах шинэ санал санаачилгаанд санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах
----	---	-----------	---	---

**ГУРАВ. МОНГОЛ ИРГЭДИЙН ХОЛБОО, ИРГЭДИЙН САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

22	Хилийн чанад дахь монгол иргэд, иргэний байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бий болгох	2016-2020	Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй Монголчуудын холбоо, ТББ-ууд, монгол сургууль болон иргэдийн мэдээллийг шинэчлэх чиглэлээр ажиллах	Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй монголчуудын холбоо, ТББ-ууд, 16 улсад 48 1-ний өдрийн байдлаар 26 улсад 129 Монголчуудын холбоо, ТББ-ууд, 16 улсад 48 монгол хэл, соёлын төвүүд үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн 76 улсад 175,000 гаруй монгол иргэд оршин сууж байгаа тоон мэдээлэл гарч байгаа бөгөөд үүнээс 50,000 гаруй иргэн хөдөлмөр эрхэлж, 49,000 орчим иргэн суралцаж байгаа болно.
23	Хилийн чанад дахь монгол иргэдийн ТББ-уудын ээлжит чуулга уулзалтыг зохион байгуулах	2016-2020	"Хилийн чанад дахь оюутан залуучуудын II чуулга, уулзалт"-ыг зохион байгуулах	Монгол Улсын Засгийн газраас баталсан "Дэлхийн Монголчууд" хөтөлбөрийн хүрээнд "Хилийн чанад дахь монгол оюутан, залуучуудын II чуулга уулзалт"-ыг энэ оны 9 дүгээр сард БНУУ-ын Будапешт хотноо зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ хүрээнд Унгар Улсад суугаа Элчин сайд З.Батбаяр Унгар Улсын Үндэсний Ассамблейн дэд дарга Шандор Лекажтай чуулга уулзалтыг зохион байгуулах газар, зочид буудлын талаар уулзаж, санал солилцсон болно.
24	"Монгол хөгжилд" орны хөгжилд уулзалтуудыг зохион байгуулах	2016-2020	"Монгол орны хөгжилд" XV дугаар чуулга уулзалтыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	"Дэлхийн Монголчууд" хөтөлбөрийн хүрээнд "Монгол орны хөгжилд" 15 дугаар чуулга уулзалт "Эрүүл мэнд, тогтолцоо" сэдвийн хүрээнд 2019 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Бүгд Найрамдах Польш Улсын Варшав хотноо зохион байгуулав.
25	Хилийн чанад дахь монгол хүүхдүүдэд монгол хэл, ёс заншил, түүх, соёлын чиглэлээр чадамж зээмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон	2016-2020	Хилийн чанад дахь монгол хүүхдүүдийн дунд эх хэл, соёлоо сэргээх, түүхээрээ бахархах сэтгэлийг нь хөхиүлэн дэмжих зорилгоор "Эх түүхийн олимпиад"-ыг зохион байгуулах	Чуулга уулзалтад дэлхийн 17 оронд ажиллаж, сурч буй 120 гаруй монгол эмч, эрдэм шинжилгээний ажилтан, оюутан залуучууд, иргэд оролцож эрүүл мэндийн тогтолцоо, Монголын уламжлалт Анагаах ухааны брэнд, эрүүл мэндийн аялал жуулчлал, тариур зүүний шинэ технологи, Европын Холбооны Улс дахь эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл зэрэг асуудлуудаар илтгэл тавьж, санал солилцсон болно.
				Хилийн чанад дахь монгол хүүхдүүдийн дунд эх хэл, соёлоо сэргээх, түүхээрээ бахархах сэтгэлийг нь хөхиүлэн дэмжих зорилгоор "Эх түүхийн олимпиад"-ыг өнгөрсөн онд хилийн чанадад болон дотоодод зохион байгуулах бөгөөд энэ онд энэхүү олимпиадыг зохион байгуулах талаар судлаж байна.

26	сурах бичиг, гарын авлага, хялбар-шуулсан хөтөлбөр руулах сургалтын боловсруулах		Хилийн чанад хэл, соёлын Монгол төвүүдийн ажиглалаганд үзүүлэх ажиллах чиглэлээр	Тайлангийн хугацаанд БСШУС-ын сайдын 2019 оны АУ08 тоот тушаалаар "Г" адаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдүүдэд монгол хэл, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх боломжийг судлан, санал боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулан ажиллаж байна. Хилийн чанад дахь монгол хэл, соёлын сургалтын төвүүдийн үйл ажиллагааг сургалтын арга зүйгээр хангах хүрээнд монголын уламжлалт тоглоом наадагд, ёс заншилын талаар танилцуулсан цахим номын сангийн тухай мэдээллийг тус газрын 2 дугаар сарын 15-ны өдрийн ө/11/19/073 тоот цахим шууданаар дамжуулан хилийн чанадад суугаа ДТГ-уудаар дамжуулан хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй монгол хэл, соёлын төвүүдэд хүргүүлэв. БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, "Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл" ТББ-ын Боловсролын хорооны төлөөлөл, БНСУ-д үйл ажиллагаа явуулж буй монгол хэл, соёлын сургуулийн багш нарын уулзалтыг 2 удаа зохион байгуулж, солонгосын багш нарыг мэргэшүүлэх, тулгарч буй болон цаашид авах арга хэмжээний талаар санал солилцсон болно.
27	Хилийн чанад дахь Монгол иргэдийн зохион байгуулах соёл, урлагийн хэмжээнд үзүүлэх дэмжлэг	2016-2020	Хилийн чанад дахь иргэд, Монголчуудын холбоодын зохион байгуулж буй соёл, урлагийн арга хэмжээнүүдэд чиглэлээр ажиглах	Хилийн чанад дахь иргэд, Монголчуудын холбоодын зохион байгуулж буй арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллав. Үндэ: - "Нарны баяр" соёл, спортын арга хэмжээ, Вена - "Ази, Африкийн улс орнуудын өдөрлөг", Варшав - "Монголын залуу манлайлагчдын хөтөлбөр", Прага - "Үзэсгэлэнт Монгол орон" гэрэл зургийн үзэсгэлэн, Варшав - "Монголын кино фестиваль", Прага - "Монгол орны хөгжилд" ХV чуулга уулзалт, Варшав - Сингалур дахь Монголын соёл, урлагийн өдрүүд, Сингалур, 2019.03.31 - "Эрдмийн баяр" хичээлийн жилийн төгсөлтийн арга хэмжээ, Варшав, Брюссель зэрэг болно.
28			"Хилийн чанад дахь Монгол иргэдийн спортын их наадам"-ыг зохион байгуулах боломжийг судлах, хэрэгжүүлэх чиглэлээр ажиглах	БСШУСЯ хилийн чанад дахь Монголчуудын холбоод, нийгэмлэгүүдийг спортын арга хэмжээ зохион байгуулахад энэ оны эхний хагас жилээс эхлэн БСШУСЯ-ны "Спортын хөгжлийн сан"-гаас санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болов. "Хилийн чанад дахь монгол иргэдийн спортын их наадам"-ыг 2019 онд зохион байгуулах боломжийг судалж энэхүү арга хэмжээг 2020 онд зохион байгуулахаар болов. Тайлангийн хугацаанд хилийн чанад дахь иргэдийн дунд зохион байгуулсан спортын арга хэмжээнүүдэд ДТГ-уудаас дэмжлэг үзүүлэн ажиллав. Үндэ: - "Польшийн цом 2019" Европ дахь Монголчуудын шагайн харвааны тэмцээн, - "Манчестерын цом" шагайн харвааны тэмцээн, Лондон - Монголчуудын сагсан бөмбөгийн тэмцээн, Будапешт, Канберра, Сингалур



				<ul style="list-style-type: none"> <li>- Элчин сайдын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн, Вашингтон,</li> <li>- Канадын баруун бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн, Оттава</li> <li>- "Спорт өдөрлөг" сагсан бөмбөгийн тэмцээн, Берлин</li> </ul> <p>ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн "Наадам"-ыг хилийн чанадад сурталчлах, хилийн чанад дахь монгол иргэдэд монголын ёс заншил, өв уламжлалаа өвлүүлэх, Монголчуудын холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Миний Монгол наадам" уралдааныг 2019 оны 7 дугаар сард хилийн чанадад зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ хүрээнд "Миний Монгол наадам-2019" уралдаант шалгаруулалтын удирдамжид санал ирүүлэх хүсэлтийг ДТГ-уудаар дамжуулан хилийн чанад дахь Монголчуудын холбоодод хүргүүлэв.</p> <p>Мөн "Миний Монгол наадам - 2019" уралдаант шалгаруулалтын эхний 3 байрны шалгалын төсвийг (15 сая төгрөг) Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас гаргуулах, "Ажил гүйцэтгүүлэх гэрээ"-г ГХЯ, Үндэсний Их Баяр Наадамд зохион байгуулах хороо, НЭДТГ-ын хооронд байгуулах чиглэлээр ажиллаж байна.</p> <p>"Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл" ТББ-аас санаачилсан "Миний Монгол наадам - Европт" арга хэмжээг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор ХБНГУ-ын Берлин хотноо 9 дүгээр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд уг арга хэмжээний бэлтгэл ажлыг эхлүүлэх, Ажлын хэсгийг байгуулах тухай албан тоотыг 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 11/1184 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Түүнчлэн "ГХЯ-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", "ГССХГ-ын 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө", "Монгол Улсаас хилийн чанадад суугаа ДТГ-аас монгол иргэдтэй 2019 онд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нуудад тус тус оруулсан болно.</p> <p>"Миний Монгол наадам - Европт" арга хэмжээг Берлин хотноо зохион байгуулах талаар Берлин дэх ЭСЯ-нд мэдээлэл хүргэж бэлтгэл ажлыг хангах талаарх чиглэлийг энэ оны эхний улиралд хүргүүлэв.</p> <p>"Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл" ТББ "Миний Монгол наадам - Европт" арга хэмжээг энэ оны 9 дүгээр сард Берлин хотноо зохион байгуулахыг хойшлуулж, улмаар 2020 оны 6 дугаар сард Берлин хотноо зохион байгуулах болсон талаарх албан тоотыг Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлсэн болно.</p> <p>Үндэсний хөгжлийн газар цахим платформыг байгуулах тухай ажлын даалгаварын саналыг боловсруулж Азийн Хөгжлийн Банк-д хүргүүлээд байна.</p> <p>2019 оны 3 дугаар срын 20-ны өдөр Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Эрдэнэбаяр "Хилийн чанад дахь Монголчуудын Зөвлөл" ТББ-ын төлөөлөгтэй уулзаж цахим мэдээллийн сан үүсгэх төслийн талаар санал солилцсон болно.</p>	
29	"Миний наадам" арга хэмжээг зохион байгуулах	Монгол	2016-2020	"Миний Монгол наадам" уралдааныг хилийн чанадад оршин сууж буй монгол иргэд, ТББ-уудын дунд зохион байгуулах	
30				"Монгол наадам – Европт" цогц арга хэмжээг ХБНГУ-ын Берлин хотноо зохион байгуулах	
31	Монгол байгууллага, аж ахуйн нэгжүүдийг олон улсад зохион байгуулагдаг үзэсгэлэн, яармагт хилийн чанадад оршин сууж буй монгол иргэдийн монгол холбоод төлөөлөн оролцох боломжийг	Улсын	2016-2020	Хилийн чанад дахь иргэд, монголчуудын холбоодын Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлэх цахим платформыг байгуулах чиглэлээр ажиллах	

	Бий болгох			
<b>ДӨРӨВ. МОНГОЛ ХЭЛ, СОЁЛ, УРЛАГ, ЗАН ЗАНШЛЫГ ӨВЛӨГЧ АРД ТҮМНҮҮДИЙН СОЁЛЫН СОЛГИЛЦОО, ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>				
32	Монгол хэл, соёл, урлаг, зан заншлыг өвлөгч ард түмнүүдтэй харилцах чиглэл, баримтлах бодлогын талаар судалгаа хийх	2016-2020	Монгол хэл, соёл урлаг, зан заншлыг өвлөгч ард түмнүүдтэй харилцах чиглэл, баримтлах бодлогын талаар судалгаа хийх	Монгол хэл, соёл урлаг, зан заншлыг өвлөгч ард түмнүүдтэй харилцах чиглэл, баримтлах бодлогын талаар судалгаа хийх.
33	Олон улсын байгууллагад бүртгэлтэй Монголчуудын холбоо байгуулах судалгаа хийх	2016-2020	Олон улсын байгууллагад бүртгэлтэй Монголчуудын холбоо байгуулах чиглэлээр судалгаа хийх	Хилийн чанад дахь Монголын соёлын төвүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх, шинээр байгуулах чиглэлээр дараахь ажлууд хийгдэв. Үүнд: 2019 оны 1 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд ГССХГ-ын захирал Х.Мандахцэцэг тэргүүтэй төлөөлөгчид БНСУ-ын Пусан болон Тэгү хотод ажлын айлчлал хийж, Пусан хотын захиргаа, Соёл, спорт аялал жуулчлалын газар, Тэгү хотын Соёлын газар, Соёлын нэгдсэн хороо зэрэг байгууллагуудын удирдлагатай уулзалт хийв. Уулзалтын үеэр хоёр талын соёлын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх. 2020 онд тохихо дипломат харилцааны 30 жилийн ойг угтан Пусан болон бусад хотуудад соёлын арга хэмжээ зохион байгуулах, Пусан хотноо Монголын соёлын төв байгуулах зэрэг асуудлуудаар санал солилцсон болно.
34	Монгол үндэстний ёс заншил, соёлын үзэмрүүдийг цуглуулан дэлхийн жишигт нийцсэн музей байгуулах санаачлага гарган төсөл хэрэгжүүлэх	2017-2020	ОХУ-ын Эрмитажийн музейд хадгалагдаж буй монголын түүх, соёлтой холбоотой эд зүйлсээр Улаанбаатар, Санкт Петербург хотуудад үзэсгэлэн чиглэлээр ажиллах	ОХУ-ын Эрмитажийн музей дэх монголын түүх, соёлын өв, дурсгалуудаар хоёр талын хамтарсан үзэсгэлэн гаргах, каталог хэвлүүлэх асуудлаар 2017 оноос Эрмитаж музей болон Монголын ШУА-тай холбогдох уулзалтуудыг хийж хамтран ажиллав. Монгол Улс, ОХУ-ын Гадаад хэргийн дэд сайд нарын түвшний зөвлөлдөх уулзалтын үеэр Эрмитажийн музей дэх монголын түүх, соёлын өв, дурсгалуудаар хоёр талын хамтарсан үзэсгэлэн гаргах ажил ахицтай байж, холбогдох каталог хэвлэгдэн гарсныг мэдээлж, үзэсгэлэнг 2019 онд багтаан хоёр талд гаргах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг анхааран, дэмжиж ажиллахыг айлын талаас хүсэв. Мөн Эрмитажийн музейн Ерөнхий захирал М.Б.Плютовскийн зүгээс хамтарсан үзэсгэлэнгийн үеэр монголын талаас зарим тодорхой үзэмрүүдийг ирүүлэхийг хүссэнийг ШУА-д уламжлан хамтран ажиллаж байна.
35	Хилийн байгаа Монгол улс	2016-2020	Хилийн чанад дахь монгол угсаатнуудын	Ардын урлаг, гар урлалын үзэсгэлэн худалдаа болох "Хаврын гайхамшиг" үзэсгэлэн 2019 оны 3 дугаар сарын 8-ны өдөр Москва хотноо зохион байгуулагдсан бөгөөд уг арга

	саатнууд монгол хэл, соёлоо сэргээх, хадгалан өвлөхөд нь дэмжлэг үзүүлэх		Монгол хэл, соёлоо сэргээх, хадгалан өвлөх чиглэлээр байгуулж буй арга хэмжээнд оролцох, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах	хэмжээнд хилийн чанад дахь монгол туургатнууд оролцож үндэсний гар урлал, арьс, савхин эдлэл, дурсгалын зүйлсээ сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлэн ажиллав.
36	Монгол туургатан оюутанг Монгол Улсын Их сургуулиудад суралцуулах тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх	2017-2020	Монгол туургатан оюутанг Монгол Улсын их, дээд сургуулиудад монгол оюутны жишээр төлбөр төлөх боломжийг судлах, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах	Монгол туургатан оюутанг Монгол Улсын их, дээд сургуулиудад монгол жишээр төлбөр төлөх боломжийг судлах, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллав.
37	Монгол хэл, соёлын дархлаа, иргэний үндэстний боловсрол, өв уламжлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудлаар хөрш орнуудтайгаа баримтлах чиглэл боловсруулж мөрдөх	2017-2020	Монгол хэл, соёлын дархлаа, иргэний үндэстний боловсрол, өв уламжлал зэрэг улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудлаар хөрш орнуудтайгаа баримтлах чиглэл боловсруулах чиглэлээр ажиллах	Монгол хэл, соёлын дархлаа, иргэний үндэстний боловсрол, өв уламжлал зэрэг улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудлаар хөрш орнуудтайгаа баримтлах чиглэл боловсруулах чиглэлээр ажиллав.
38	Монгол хэл, соёл, зан заншил, өвлөн уламжлагч ард түмнүүдийн соёлын солилцоо, харилцаа, хамтын ажиллагаа явуулахад мэдээллийн дэмжлэг үзүүлэх	2016-2020	Монгол үндэстний өв соёл, зан заншил, соёл урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах зорилго бүхий "Нүүдэлчин" наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах	Монгол үндэстний өв соёл, зан заншил, соёл урлагийг дэлхий нийтэд таниулах зорилго бүхий "Нүүдэлчин" наадмын ээлжит арга хэмжээ болох "Дэлхийн нүүдэлчдийн V наадам"-ыг Улаанбаатар хотноо зохион байгуулахаар хоёр тал Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын Бүгд Найрамдах Киргиз Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр тохиролцсон болно.
39	Олон улсын Монгол судлалын төвийг Улаанбаатар хотноо байгуулах ажлыг дэмжин ажиллах	2017-2020	Ази болон Европын бүсийн Монгол судлалын бүсчилсэн ээлжит семинарыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах	Монгол судлалын Европын бүсийн III хурлыг "Монголын бурханы шашин: уламжлал ба шинэчлэл" сэдвээр Будапешт хотноо 4 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллав. "Монгол судлалын олон улсын 13 дугаар бага хурал"-ыг АНУ-д, "Монгол-Турк судлал эрдэм шинжилгээний хоёрдугаар бага хурал"-ыг Турк Улсад тус тус зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав.

			<p>Монгол судлалын Үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Австрийн Шинжлэх ухааны академид монгол судлалын Отон Улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, БНАСАУ-ын Пёнъяны их сургуулийн Монгол судлалын тэнхимийг "төв" болгон өргөжүүлэх, ОХУ, Австри, Унгар, Герман, Канад, Их Британи, Өмнөд Солонгос дахь монгол судлалыг дэмжих арга хэмжээнүүдийг тусгуулан хамтран ажиллаж байна.</p>
40		<p>"Дэлхийн судлалын танхим"-ыг ном, баяжуулах</p> <p>МОНГОЛ УНШЛАГЫН ХОЛБОГДОХ СЭТГҮҮЛЭЭР</p>	<p>МУИС-ийн шинэ номын сан дахь "Дэлхийн монгол судлалын уншлагын танхим"-ыг ном, эрдэм шинжилгээй бүтээл, сэтгүүл, судалгааны материалуудаар баяжуулан ажиллаж байна.</p>
41		<p>"Монгол судлалын шилдэг өв"-ийн цуврал бүтээлүүд болон монголын түүх, соёл, сурвалж бичгийн талаарх судалгааны бүтээлүүдийг хэвлүүлэх, МОНГОЛ СУДЛААЧДАД ТҮГЭЭХ</p>	<p>"Монгол судлалын шилдэг өв"-ийн цуврал бүтээлүүдийг хэвлэх ажлыг перс хэл дээр бичигдсэн монголын түүхийн гурван сурвалж, эртний итали хэл дээр бичигдсэн Марко Пологийн тэмдэглэлийн орчуулгын ажил дууссан бөгөөд хэвлүүлэх чиглэлээр ажиллаж байна.</p>

-----000-----